

ГАРЧИГ

МОНГОЛ УДСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООД

173.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 37	481
174.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 40	482

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 2 дугаар
сарын 14-ний өдөр Дугаар 37 Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 7.2, 30.1 дэх хэсгийг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 410 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.3, 2.4 дэх хэсэг, 4.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

- “2.3. Цахим тоглоомын үйлчилгээ үзүүлэх газар нь 23.00 цаг хүртэл үйлчилнэ.”;
 - “2.4. 9-16 хүртэлх насанд хүрээгүй хууходдэд зуны улиралд (4 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаа) 20.00 цаг, өвлийн улиралд (10 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаа) 18.00 цаг хүртэл үйлчлэх бөгөөд өдөрт нэг удаа 2 цагаас илүүгүй хугацаагаар үйлчилнэ.”.

3. “4.1.3. энэхүү журамд заасан цахим тоглоомын үйлчилгээг 9 насанд хүрээгүй хувьхдэд үзүүлэх.”.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХҮЯГ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 2 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийг 1 дүгээр, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. “Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон 2014 оны үйл ажиллагаанд шаардагдах 712.757.500 (долоон зуун арван хоёр сая долоон зуун тавин долоон мянга таван зуун) төгрөгийг батлан хамгаалахын 2014 оны төсөвт зохицуулалт хийж санхүүжүүлэхийг зөвшөөрч, цаашид шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Их, дээд сургуулиудын оюутан залууст суралцах хугацаанд нь цэргийн ерөнхий бэлтгэл болон цэргийн тусгай бэлтгэл сургалтыг зохион байгуулж цэргийн алба хаалгах журам боловсруулан ажиллахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантэмэр нарт тус тус даалгасугай

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Д.БАТ-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2014 оны 40 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЮУТАН-ЦЭРЭГ ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

Зэвсэгт хүчнийг 1990-ээд оноос цомхотгож, хугацаат цэргийн алба хаагчийн тоо цөөрсөн, хуулийн дагуу их, дээд сургуулийн оюутнуудыг



суралцах хугацаанд нь цэргийн албанаас чөлөөлж байгаагаас иргэн бүр “Монгол Улсын Үндсэн хууль”-аар хүлээсэн “эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” үүргээ биелүүлж чадахгүй байна.

Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэгт мөрдөж байгаа өнөөгийн орон тоогоор жил тутам цэргийн насанд (18) хүрч байгаа нийт залуусын 30 хувийг л хугацаат цэргийн албанд татах боломжтой.

Ийм нөхцөл байдал 20 гаруй жил үргэлжилснээр цэргийн зохих бэлтгэлтэй Зэвсэгт хүчний дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний хомсдолд орж, улс орны батлан хамгаалах чадавхийг сулруулаад зогсохгүй залуусын эх оронч хүмүүжил, төлөвшил, эрүүл мэнд, бие бялдрын хөгжилд сөргөөр нөлөөлж байгаагаас гадна Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн жинхэнэ албандаа ажиллах нөхцөлийг хязгаарлаж байна.

Цэргийн насны залуусын цэргийн алба хаах хуулиар хүлээсэн иргэний үүргээ биелүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд төрөөс анхаарал хандуулах шаардлага гарч байна. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цэргийн алба хаагчдыг нөхөн хангах бодлогыг шинэчлэн, холимог тогтолцоог төлөвшүүлж, иргэдийн цэргийн алба хаах хэлбэрт шинэчлэл хийх” зорилтыг тусгасан ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлиг гарсан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

2. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнуудыг суралцах хугацаанд нь цэргийн эрчимжсэн сургалттай тусгай хөтөлбөрөөр цэргийн бэлтгэл сургалтад хамруулан цэргийн алба хаалгах бололцоог бүрдүүлэх, эх орноо батлан хамгаалах, төрийн алба хаших, эрүүл чийрэг, бие бялдар, сэтгэл зүйн болон цэргийн бэлтгэлтэй залуусын тоог нэмэгдүүлж, улс орныг батлан хамгаалах чадавхийг сайжруулан дайчилгааны бэлтгэл үүрэгтний нөөцийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

2.2.1. Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнуудыг суралцах хугацаанд нь сайн дурын үндсэн дээр цэргийн алба хаах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.2.2. оюутнуудыг суралцах хугацаанд нь сайн дурын үндсэн дээр сонгон суралцахаар цэргийн алба хаах, цэргийн бэлтгэл сургалтад хамруулах;

2.2.3. хөтөлбөрийг хэрэгжүүлэх цэргийн сургалтын төвийг Зэвсэгт хүчний жанжин штаб, Батлан хамгаалах их сургуулийн сургалтын материаллаг баазыг түшиглэн байгуулах.

3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.2. их, дээд сургуулийн оюутан залуусыг суралцах хугацаанд нь цэргийн алба хаалгах журам боловсруулан батлах;

3.1.3. “Оюутан-цэрэг хөтөлбөр”-т зориулсан цэргийн алба, сургалтыг зохион байгуулах заавар боловсруулан гаргах.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. “Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийн цэргийн сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж баттуулах;

3.2.2. их, дээд сургуулиудтай хамtran сайн дурын үндсэн дээр цэргийн алба хаах сонирхолтой оюутнуудад “Цэргийн өрөнхий бэлтгэл” хичээлийг (2 кредит, 96 цаг) сонгон суралцуулах;

3.2.3. уг хөтөлбөрийн 3.2.2-т заасан шаардлагыг хангасан оюутан залуусыг цэргийн тусгай бэлтгэл сургалтад (12 кредит, 560 цаг) хамруулж, дайчилгааны нөөцийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэж, хугацаат цэргийн албыг хаасанд тооцох.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин, материаллаг баазыг бүрдүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;



3.3.2. сургалтын төвийн байр, анги, танхimuудын барилгын ажлыг дуусгаж, цэргийн сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлж, жилийн турш тасралтгүй сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

**4.Хөтөлбөрийн удирдлага, зохион
байгуулалт, санхүүжилт**

4.1. Зэвсэгт хүчний жанжин штаб болон Батлан хамгаалах их сургууль нь “Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж, сургалт, зохион байгуулалт, материаллаг баазаар хангана.

4.2. Батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь “Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, үр дүнд тогтмол хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.

4.3. “Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж буй ажлын явцын талаар жил бүрийн 12 дугаар сард багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид илтгэж, олон нийтэд мэдээлэл хийх ажлыг Батлан хамгаалах асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн хариуцна.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсвөөс бүрдүүлнэ.

5.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

5.1. Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнууд суралцах хугацаандаа цэргийн алба хаах хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

5.2. Оюутнууд цэргийн алба хаах болсноор Зэвсэгт хүчний дайчилгааны бэлтгэл үүрэгтний нөөц нэмэгдэж, улс орны батлан хамгаалах чадавх сайжирч, их, дээд сургуулийн төгсөгчид төрийн албанад орох нөхцөл бүрдэнэ.

5.3. Оюутан залуус их, дээд сургуульд суралцах хугацаандаа цэргийн ерөнхий бэлтгэл, цэргийн тусгай бэлтгэл сургалтад хамрагдах замаар цэргийн жинхэнэ албыг биеэр хаах боломж бүрдэнэ.

5.4. Цэрэг эх оронч хүмүүжил, төлөвшилтэй, эрүүл чийрэг, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлтэй иргэдийн тоо нэмэгдэнэ.



Засгийн газрын 2014 оны 40 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

“ОЮУТАН-ЦЭРЭГ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
1. Монгол Улсын их, дээд сургуулийн оюутнуудыг суралцах хугацаанд нь сайн дурын үндсэн дээр цэргийн алба хаах эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар			
1.1	Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2014 оны 2 дугаар улиралд	БХЯ
1.2	Их, дээд сургуулийн оюутан залуусыг суралцах хугацаанд нь цэргийн алба хаалгах журам боловсруулан батлуулах	2014 оны 1 дүгээр хагаст	БХЯ, БШУЯ, СБТГ
1.3	“Оюутан-цэрэг хөтөлбөр”-т зориулсан цэргийн алба, сургалтыг зохион байгуулах заавар боловсруулан гаргах	2014 оны 1 дүгээр хагаст	БХЯ, БХИС
1.4	Их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан залуусын “Оюутан-цэрэг хөтөлбөр”-т хамрагдах судалгааг гаргах	Жил бүрийн 9 дүгээр сард	БХЯ, МОХ
1.5	“Оюутан-цэрэг хөтөлбөр”-т хамрагдсан оюутан залуусыг цэргийн алба хаасанд тооцох, элсүүлэх, хасах тухай тусгай журам боловсруулж батлуулах	2014 он	БХЯ



2. Оюутнуудыг суралцах хугацаанд нь сайн дурын үндсэн дээр сонгон суралцахаар цэргийн алба хаах цэргийн бэлтгэл сургалтад хамруулах талаар

2.1	“Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийн цэргийн сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах	2014 он	ЗХЖШ, БХИС
2.2	Их, дээд сургуулиудтай хамтран сайн дурын үндсэн дээр цэргийн алба хаах сонирхолтой оюутнуудад “Цэргийн ерөнхий бэлтгэл” хичээлийг (2 кредит, 96 цаг) сонгон суралцуулах	2014-оноос	БШЯ, БХЯ
2.3	“Цэргийн ерөнхий бэлтгэл” хичээлийг судалж, шаардлага хангасан оюутан залуусыг цэргийн тусгай бэлтгэл, сургалтад (12 кредит, 560 цаг) хамруулах	2014 оноос	БХЯ, ЗХЖШ, БХИС
2.4	“Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийн хүрээнд эхний ээлжинд 500 оюутны сургалтыг цэргийн ангиудыг түшиглэн зохион байгуулах	2014 он	ЗХЖШ, БХИС
2.5	“Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийн цэргийн сургалтыг явуулах багш, офицерүүдийг жил бүр сургалт, семинарт хамруулах	Жил бүр	БХЯ, БХИС
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх цэргийн сургалтын төвийг Зэвсэгт хүчний жанжин штаб, Батлан хамгаалах их сургуулийн сургалтын материаллаг баазыг түшиглэн байгуулах талаар			
3.1	“Оюутан-цэрэг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх цэргийн сургалтын төвийг байгуулах зураг төсөл, төсвийг гаргах	2014 он	БХЯ, БХИС
3.2	Сургалтын төвийн байр, анги, танхимуудын барилгын ажлыг дуусгах	2015-2016 он	БХЯ



3.3	Сургалтын төвийг иж бүрнээр ашиглалтад оруулж, жилийн турш тасралтгүй сургалт явуулах нөхцөл бүрдүүлэх	2016-2017 он	БХЯ
3.4	“Оюутан-цэрэг” сургалтын төвийн цэргийн сургалтын хотхонуудыг барьж дуусгах	2016 он	БХЯ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн худас: 0.5

Индекс: 14003